

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.ЦОЛМОНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1: Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх							
1	Гадаад худалдаа эрхлэгчид барааны ангиллын кодын талаар мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	80%	1. Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд барааны ангиллын талаас санал өгөх, барааны ангиллын кодыг тодорхойлох; 2. Шаардлагатай тохиолдолд үндэсний код, хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулах; 3. Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулан шийдвэрийн санг баяжуулах; 4. "Хиймэл оюун ухаанд суурилсан БТКУС-ийн код санал болгох платформ"-ын туршилтыг хийх; 5. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай конвенц, түүний хавсралтыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлүүлэх ажлыг зохион байгуулах; 6. Аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн барааны ангиллын кодыг урьдчилан	1. ГТГТТХ-ийн 38.1.20, 38.1.21, 40.4 болон 40.5-т заасны дагуу, ЗГ-ын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгуулах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв аймгийн Баян сумд баригдах цахилгаан станцын зориулалттай 1700 барааны кодыг тодорхойлж, ЭХЯ, СЯ-нд хүргүүлсэн. 2. ДГБ-ын НБД нарын газраас ирүүлсэн [redacted] [redacted]-ийн барааны ангиллын талаар ирүүлсэн зөвлөмжийг монгол хэлнээ орчуулж, МЗХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгууллаа. МЗХ-аас гарсан шийдвэрийн дагуу Дэлхийн гаалийн байгууллагад барааны ангиллын чиглэлээр асуудал хэлэлцүүлэхтэй холбогдуулан албан захиа хүргүүлж, ДГБ-ын 9 сард хуралдах 76 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа хүргүүлсэн. Мөн ДГБ-аас ирүүлсэн ангиллын зөвлөмжийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал асуулгыг ДГБ-д бэлтгэн хүргүүллээ. ДГБ-аас хариу албан захиа ирүүлсний дагуу бэлтгэл ажлын хүрээнд бараатай холбоотой зарим нарийвчилсан үзүүлэлтүүд, техникийн шаардлага зохицуулалтуудын талаар холбогдох тайлбарыг бэлтгэн хүргүүлэхээр ажиллаж байна. Гаалийн газар, хороодод ДГБ-ын барааны ангиллын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай ГЕГ-ын дэд	01.01-06.10	95%

			тодорхойлуулах хүсэлтийг шийдвэрлэх; 7. Барааны ангиллын чиглэлээр гаалийн улсын байцаагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах, чиглэл, зөвлөмжөөр хангах.	даргын 2025 оны 04 сарын 03-ны өдрийн 02/1361 тоот албан бичгийг хүргүүлсэн. 3. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай конвенц, түүний хавсралтыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлүүлэх ажлын хүрээнд УИХ-ын Тамгын газарт албан бичиг хүргүүлж ажилласан. 4. "Хиймэл оюун ухаанд суурилсан БТКУС-ийн код санал болгох платформ"-ын туршилтыг хийх ажлын хүрээнд Ази номхон далайн бүс нутгийн төвд албан бичиг төлөвлөн хүргүүлсэн. ▪ [redacted] ийн ирүүлсэн [redacted] гэх 3 барааны ангиллын маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд дараах судалгаануудыг хийлээ: ○ [redacted] компанийн 2010-2025 оны бууны мэдээллийг цуглуулж, тоу gun эсэх талаарх судалгаа ○ Дээрх барааны талаар япон болон англи хэл дээр холбогдох сайтаас мэдээлэл цуглуулах ○ Гаалийн бүрдүүлэлтийн сүүлийн 5 жилийн судалгаа БТКУС-ийн УС-ийн Тайлбар болон холбогдох судалгааг үндэслэн энэхүү бараа нь Зүйл 93.06-д ангилагдахыг тодорхойлсон. ▪ ДГБ-ын барааны ангиллын 2008, 2009, 2022 оны 55 барааны шийдвэрүүдийг орчуулж, хянах ажлыг хийж гүйцэтгэсэн. ▪ gaali.mn шинэчлэх ажлын хүрээнд БТКУС-ийн тайлбар бичгийн 1-28-р, 44-70-р бүлгийн Зүйлийн тайлбарыг 2022 оны нэмэлт, өөрчлөлтийг тусган шинэчлэн, орчуулгыг хийж тус сайтад оруулахад бэлэн болгосон, ▪ Тайлбар бичгийн 2017 оны Боть 1 болон 3-ийг 2022 оны нэмэлт, өөрчлөлтүүдийг багтааж шинэчилсэн. Дээрх орчуулгыг	
--	--	--	--	---	--

					нэгтгэн хянах, ижилтгэх ажлуудыг хийж байна. Сургалтын талаар: Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс хүсэлт тавьсны дагуу Дэлхийн Гаалийн Байгууллагаас “Уялдуулсан систем болон Барааны Ангиллын Урьдчилсан Шийдвэр” сэдэвт үндэсний хэмжээний сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтыг Дэлхийн гаалийн байгууллагын Тариф, худалдааны газрын Техникийн ахлах мэргэжилтэн хатагтай Ламиа Фригуй, ДГБ-ын УС-ийн эксперт Хатагтай Яра Новись БНСУ-ын Эдийн засаг, Сангийн яамны Аж үйлдвэрийн тарифын хэлтэс, ДГБ-ын УС-ийн эксперт Хатагтай Сери Ким нар удирдан явууллаа. Сургалтад ГЕГ-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Хяналт, бүрдүүлэлтийн газар, Зөрчилтэй тэмцэх газар, Татварын орлогын газар, Эрсдлийн удирдлагын хэлтэс, Хорио цээрийн хэлтэс, Бүрдүүлэлтийн цахим төв, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Гаалийн төв лаборатори, Улаанбаатар дахь гаалийн газар, Сэлэнгэ дэх гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар, Улс хоорондын шуудангийн газрын нийт 28 ГУБ нар амжилттай оролцлоо. Сургалтыг зохион байгуулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган хариуцах алба хаагчдыг томилсон. Сургалт нь лекц, семинар, багийн ажил, асуулт хариулт ба хэлэлцүүлэг гэсэн хэлбэрээр нийт 25 цагийн хичээлийг зохион байгуулсан ба сургалтад хамрагдагсад хичээлийн агуулгыг бүрэн хүргэх зорилгоор БАҮХ-ийн дарга Ч.Чимгэрэл, ГУАБ Н.Цолмон, ГУБ Ц.Урантуул, ГУБ Г.Баярмаа нар англи хэлнээс монгол хэл рүү дагах орчуулга хийн хүргэсэн. ДГБ-аас нийт 11 хичээлийн сэдвийг хамарсан ба ирүүлсэн хичээлийн слайдуудыг тус		
--	--	--	--	--	--	--	--

хэлтсийн алба хаагчид доорх байдлаар хуваан авч англи хэлнээс монгол хэл рүү орчуулан бэлтгэсэн.

Сурталчилж ажилласан байдал:

Сургалтын эхний өдөр БАҮХ-ийн ГУБ Ч.Урантуул гаалийн байгууллагын нийт албан хаагчдад зориулан ОНХА-аар дамжуулан сургалтын зорилго, ач холбогдол болон сургалтаас гарах үр дүнгийн талаар МОНГОЛЫН ГААЛЬ пейж хуудсанд ярилцлага өгч сурталчлан танилцуулан ажилласан. Мөн ДГБ-ын сургалтын талаар хэвлэлийн мэдээлэл бэлтгэн ОНХА-д хүргүүлж, МОНГОЛЫН ГААЛЬ пейж хуудсанд байршуулсан.

Мөн сургалтын төгсгөлд Дэлхийн Гаалийн Байгууллагын (ДГБ) Ахлах техникийн ажилтан Ламиа Фригүй ГЕГ-ын ОНХА-наас УС-ийн ач холбогдол, УС-ийг хэрэгжүүлэхэд гаалийн байгууллагууд ямар бэрхшээлтэй тулгардаг, ДГБ-аас гишүүн орнууддаа хэрхэн дэмжлэг үзүүлдэг талаар дэлгэрэнгүй ярилцлага өгсөн. Мөн УС-ийг хэрэгжүүлэх нь худалдааг хөнгөвчлөх цаашлаад уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн эдийн засгийг тогтвортой дэмжихэд ямар үр ашигтай талаар цаг үеийн хийгээд өргөн цар хүрээг хамарсан мэдээлэл хүргэсэн. Ярилцлагыг англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлж орчуулах ажлыг БАҮХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл зохион байгууллаа.

Үр дүн:

- ГУБ нар сургалтанд хамрагдсанаар барааны ангиллын нэгдмэл байдлыг хангах, ангиллын урьдчилсан шийдвэр гаргах зэргээр гаалийн байгууллагын чадахийг нэмэгдүүлэхээс гадна бизнес эрхлэгчид барааны ангиллыг урьдчилан тодорхойлуулснаар татвараа урьчилан тооцоолох, бизнес төлөвлөлтөө хийхэд нэн чухал алхам болж байна.
- ДГБ-ын экспертүүдээс Монголын гаалийн байгууллагад барааны ангиллын урьдчилсан шийдвэрийн тогтолцоог бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудлын хүрээнд ДГБ-аас онош зүйн дүн

					шинжилгээ хийх хөтөлбөр /WCO Diagnostic mission/ хэрэгжүүлэх бүрэн боломтой талаар мэдэгдсэн нь чухал ач холбогдолтой болсон.		
2	Зарим барааны гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлыг өргөжүүлэх Гаалийн үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цахимжуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	1. Үнийн хяналтыг цахимжуулах боломжтой барааны судалгааг хийсэн байна. 2. Гаалийн үнийг системээс хянах барааны шалгуур мэдээллийг гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системд оруулж, зарим барааны гаалийн үнийг системээс автоматаар хянасан байна. 3. Системээс автоматаар урьдчилан оруулсан шалгуур үзүүлэлтийг харьцуулан хянаж, зарим барааны үнийн мэдээллийг автоматаар "Баталгаажсан үнийн сан"-д оруулах боломжийг бүрдүүлнэ. 4. Үнийн мэдээллийн сангийн баталгаажсан үнийн санг 125,000 барааны үнээр баяжуулах 5. Чирэгч, чиргүүл, ачааны болон суудлын машин, өөрөө буулгагч зэрэг тээврийн хэрэгслийн үнийн судалгааг хянаж, баталгаажуулах, үнийн хяналтын зорилгоор ашигласан байна. 6. Барааны бүрдүүлэлтийн гаалийн дундаж үнийн мэдээлэл, татварын нэхэмжлэх дахин үүсгэсэн	1. Экспортын 100 горимоор бүрдүүлэлт хийж байгаа, хяналтын улаан төлөвт сонгогдсон, БТКУС-ийн зүйл 26.01, 26.03, 27.01, 27.02-т хамаарах төмрийн хүдэр болон баяжмал, зэсийн хүдэр болон баяжмалыг биржийн гэрээтэй тохиолдолд системээс автоматаар шалгаж, гаалийн үнийг баталгаажуулах боломжтой эсэх талаар судалгаа хийсэн. Програмын талаар МТГ-т 2025.04.03-ны 02-2.1/140 дотоод зурвасаар санал хүргүүлж, ажилласан. ХБГ-аас санал авахаар 2025.05.08-ны өдрийн 02-2.1/175 дотоод зурвас хүргүүлсэн, одоогоор хариу санал ирээгүй байна. 2. Бүрдүүлэлтийн цахим төвтэй хамтран үнийн хяналтыг цахимжуулах ажлын хүрээнд 2025.01.01-ний өдрөөс эхлэн Toyota Prius, Aqua, Sai маркийн автомашины 79 шалгуур, 2 дугаар улиралд 71 шалгуур, 2025.06.07-ны өдрөөс Toyota Alphard, Vellfire, Lexus LX250 маркийн автомашинуудын 49 шалгуурыг системд баталгаажуулсан. 2025 оны 06 сарын 08-ны байдлаар Япон улсаас импортолсон 51,075 автомашины 5940 машин буюу 11.6%-ийг системээс хянаж баталгаажуулсан байна. 3. Үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх 2 програмын саналыг боловсруулж, МТГ-т хүргүүлэн, програмыг туршилтаар нэвтрүүлээд байна. Үүнд: - Суудлын автомашиныг системээс автоматаар шалгах шалгуурын дагуу системээс гаалийн үнийг шалгаж баталгаажуулсан мэдүүлгийн тухайн өдөрт нь CAIS-ийн үнийн мэдээллийн сангийн баталгаажсан үнийн санд автоматаар ордог байхаар програмыг саналыг МТГ-т хүргүүлж нэвтрүүлсэн. Системийг 2025.01.01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, 5940 автомашины үнийн мэдээлэл автоматаар	01.01-06.10	95%

			мэдүүлгийн мэдээллийг дашбоардаар гаргах програмын бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн газарт хүргүүлэн хийлгэж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигласан байна. 7. Хил орчмын үнийн судалгааг хянаж, баталгаажуулан үнийн хяналтын зорилгоор ашигласан байна.	баталгаажсан нь ҮМС-д оруулсан нийт бичлэгийн 11%-ийг эзэлж байна. - Ангиллын хэмжих нэгж кг-аар илэрхийлэгдэх, БТКУС-ийн нийт 55 бүлэгт хамаарах 1650 кодын барааг системд урьдчилан оруулсан 9 шалгуур үзүүлэлтийн дагуу автоматаар шалгаж, ҮМС-д оруулах боломжтой байна гэж судлан CAIS системд 57,926 шалгуурыг бүртгэсэн. Тус програмыг 2025.05.15-ны өдрөөс эхлэн туршиж үзэхэд өдөрт дунджаар 107 барааны бичлэгээр баяжсан үр дүнтэй байна. Энэ нь 1 ГУБ-ийн өдөрт хянах ёстой бичлэгийн 21%-ийг эзэлж байна. Иймд үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх ажлын туршилт амжилттай хийгдсэн тул Мэргэжлийн зөвлөлийн хурлаар танилцуулж, 9 шалгуурыг батлуулах, програмыг нэвтрүүлэх зөвшөөрлийг авахаар танилцуулга бэлтгэн хэлэлцүүлэх асуудалд оруулахаар 2025.06.02-ны өдөр ЗУГ-т хүргүүлэн, материалыг бэлдсэн. 4. Үнийн мэдээллийн сангийн баталгаажсан үнийн санг 87000 барааны үнээр баяжуулан ажилласан. 5. Бүрдүүлэлтийн цахим төвөөс ирүүлсэн дараах үнийн судалгааг хянаж, дотоод зурвасаар чиглэл хүргүүлэн, системд баталгаажуулах арга хэмжээг авч, үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Үүнд: - Америкаас импортолж буй Lexus LX570, RX450H, RX350 Toyota 4Runner, Highlander маркийн суудлын автомашины үнийн судалгааг хянаж, CAIS системийн автомашины үнийн судалгаа хэсэгт 01202501000001 дугаартай хавтсанд 59 үнийн мэдээлэл, - БНСУ-аас импортлогдсон ачааны автомашин, шатахуун тээвэрлэгч автоцистерний гаалийн үнийн судалгааг хянаж, 2 удаа чиглэл хүргүүлэн, CAIS	
--	--	--	--	--	--

системийн тээврийн хэрэгслийн үнийн судалгаа хэсэгт 01202501000008 дугаартай хавтсанд 53 үнийн мэдээлэл,

- БНХАУ-аас импортлогдсон өөрөө буулгагч автомашины 72 үнийн мэдээллийг CAIS системийн тээврийн хэрэгслийн үнийн судалгаа хэсэгт 01202501000009,

- БНХАУ-аас импортлогдсон чирэгч автомашины 151 үнийн мэдээллийг CAIS системийн тээврийн хэрэгслийн үнийн судалгаа хэсэгт 01202501000010,

- БНХАУ-аас импортлогдсон чиргүүлийн 61 үнийн мэдээллийг CAIS системийн тээврийн хэрэгслийн үнийн судалгаа хэсэгт 01202501000011 дугаартай хавтсанд тус тус байршуулсан.

- БНСУ-аас импортолж буй суудлын автомашины судалгааг хянаж, холбогдох чиглэлийг 2 удаа хүргүүлж, суудлын автомашины 98 үнийн мэдээллийг 01202502000004 хавтсанд, микравтобусны 12 үнийн мэдээллийг 01202502000005 хавтсанд тус тус баталгаажуулсан.

6. Гаалийн үнийн хяналт, дүн шинжилгээний зорилгоор Tablue программд дашбоард-р гаргах дараах 3 бодлогын даалгавар боловсруулж МТГ-т хүргүүлсэн. Үүнд:

1. Дахин нэхэмжлэх үүсгэж байгаа байдалд өдөр тутмын хяналт тавих, дүн шинжилгээ хийх,

- Дахин нэхэмжлэх үүсгэж татвар бууруулсан мэдүүлгийн жагсаалт,

- Бууруулсан татварын дүн, бараагаар

- Бичиг баримтын байцаагчийн хувийн дугаараар, дамтамж

2. Автомашины бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх

- Гаалийн үнэ, үнэлгээний аргаар

- Системээс гаалийн үнийг хянаж, баталгаажуулсан мэдүүлэг, шалгуурт баригдаагүй тайлбараар,

3. Үнийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх,

					• Үнийн мэдээлийн сангийн бичлэг, барааны кодоор • Үнийн мэдээллийн сан дахь үнээр гаалийн үнийг тодорхойлсон байдал • Үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх програмын дагуу автоматаар орсон үнийн мэдээлэл 7. Хил орчмын үнийн судалгаа хянаж, ажилласан байдал. - Замын-Үүд дэх гаалийн газраас ирүүлсэн 2025.04.22-ны өдрийн 301 тоот албан бичгээр ирүүлсэн хил орчмын 68 нэр төрлийн барааны үнийн судалгааг хянаж, 2025.04.25-ны өдрийн 02-2.1/1696 тоот албан бичгээр чиглэлийг хүргүүлж, судалгааг CAIS-ийн "Хил орчмын үнийн судалгаа" хэсэгт 0320250200001 дугаартай хавтсанд байршуулан үнийн хяналтын зорилгоор 2025.04.30-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллаж эхэлсэн. - БӨГГ-аас 2025.04.25-ны өдрийн 01/191 тоот албан бичгээр ирүүлсэн хил орчмын барааны үнийн судалгааг хянасан. Гаалийн бүрдүүлэлтийн сүүлийн 2 жилийн мэдээлэл тус гаалийн газарт хийгдсэн бүрдүүлэлтийн 98%-ийг хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг хянасан байна. Хэлцлийн бус аргаар гаалийн үнийг хянасан барааны хувьд тус гаалийн газраас ирүүлсэн үнийн судалгааны үнэтэй харьцуулан CAIS системийн үнийн мэдээллийн санг шинэчлэн баяжуулах арга хэмжээг авсан тул судалгааг хил орчмын үнийн судалгаанд оруулах шаардлагагүй байгаа талаар 2025.05.09-ний өдрийн 02-2.1/1934 тоот албан бичгээр хариу мэдэгдсэн.		
3.	Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрлийн системд гаалийн зуучлалын үйл ажиллагааг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90	Эхний хагас жилд: 1.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулна.Гаалийн газар, хороод, гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд	1.Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалын хавсралтаар "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлуулсан. Журмыг гаалийн газар, хороод болон Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоогоор дамжуулж гаалийн зуучлагч, ГБМ нарт хүргэсэн. Мөн https://customs.gov.mn/-д байршуулсан. Журам батлагдсантай холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ГЕГ БЦТ, УБГГ, ЗУГГ, БЦТ, СЭГГ, БӨГГ, ГСГГ, ЧХОУНБГГ,	01.01-06.10	95

	эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах асуудлыг шийдвэрлэх			сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулсан байна. 2.Тусгай зөвшөөрлийн цахим системд баталгааны хуудас, гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх хуудсыг тусгаж, цахимжуулна. 3.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг тусгай зөвшөөрлийн цахим системд шийдвэрлэсэн байна. 4.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний алдаа суурь түвшингээс 5-аас дээш хувиар буурсан байна.	ХАГГ, ХОГГ-тай онлайн хурлаар журмын танилцуулга, гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд хяналт тавьж ажиллах талаар болон журмын зүйл, заалт дахь агуулгыг нэг мөр ойлгох талаар чиглэл, зөвлөмжөөр хангаж ажилласан. Мөн 2025 онд зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний 3 удаагийн анхан шат, 3 удаагийн давтан сургалтад нийт 356 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд журмын танилцуулга, хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар 12 цагийн хичээл заасан. 2. Журам батлагдсантай холбогдуулан СМТТ УТҮГ-т тусгай зөвшөөрлийн цахим системд оруулах засвар, өөрчлөлтийн талаар 2025.01.31-ний өдрийн 02-2.1/548 дугаартай албан бичиг хүргүүлсэн, 2025.03.12-нд онлайн уулзалтыг хийж, програмын даалгаврын талаар хэлэлцсэн. 2025.05.08,15,22-ний өдрүүдэд онлайнаар туршилт хийсэн. ГБМ-ий өөрийн үнэлгээний хуудасны үзүүлэлт 18 байсныг 9 болгосон засварыг хийж гүйцэтгэсэн. Гаалийн зуучлагчийн баталгааны хуудсыг хүсэлт гаргахдаа Бүрдүүлэх материал хэсэгт PDF-ээр хавсаргаж өгөх байдлаар оруулж програмын өөрчлөлтийг хийсэн. 3. Зөвшөөрөл олгосон: Эймид ложистик ХХК, ХББПБ ХХК, Наран яруу ложистик ХХК-иудын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хянаж баталгаажуулан хүргүүлж, Сангийн сайдын 2025 оны 4, 54 тоот тушаалаар зөвшөөрөл олгосон. Сангийн яаманд хүргүүлсэн: [REDACTED] Х-иудын зөвшөөрөл хүссэн, [REDACTED] -ийн зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг тусгай зөвшөөрлийн цахим системд хүлээн авч хянан, баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлсэн. Гаалийн байгууллагад хянагдаж байгаа: [REDACTED] зөвшөөрөл хүссэн хүсэлт, ирүүлсэн материалуудыг хянаж, зөвөлгөө өгч ажиллаж байна. 4. 2024 оны 06 сарын 09-ны өдрийн байдлаар нийт 1245172 бичлэг бүхий бараанд экспортын 322508, импортын 177990, нийт 500498 гаалийн мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн. 2025 оны 06 сарын 09-		
--	--	--	--	--	--	--	--

ны өдрийн байдлаар нийт 1318903 бичлэг бүхий бараанд экспортын 292954, импортын 187656 нийт 480610 гаалийн мэдүүлэг бичигдсэн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бичлэгийн тоо 73731 буюу 5,6%-аар өссөн, экспорт 29553 буюу 9,1%-иар буурсан, 9666 буюу 5,1%-иар өссөн, нийт гаалийн мэдүүлгийн тоо 19888 буюу 3,9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Барааны бичлэг болон гаалийн мэдүүлгийн тоонд цахим /өөрөө/-аар болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээр мэдүүлснийг дараах байдлаар харуулвал:

	2024 оны 06.09-ны байдлаар				2025 оны	
	Цахим/өөрөө/		ГБМ		Цахим/өөрөө	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бич	409453	32,9%	835719	67,1%	396055	30,0%
Мэд	271693	45,7%	228805	54,3%	241436	50,2%

2024 оны мөн үеийн байдлаар 1245172 бичлэг бүхий бараанд нийт 500498 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 36995 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүний 29852 нь гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээс засварт буцаасан, гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр 6283 гаалийн мэдүүлэг буцаагдаж, нийт алдаатай мэдүүлгийн тоо 23569 байна. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 1,9% байна.

2025 оны тайлант үеийн байдлаар 1318903 бичлэг бүхий бараанд нийт 480610 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 44266 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүний 34394 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээс засварт буцаасан, гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр засварт буцаасан гаалийн мэдүүлгийн тоо 7716 байна. Алдаатай гаалийн мэдүүлгийн тоо 26678 байгаа бөгөөд нийт алдаатай мэдүүлгийн тоог нийт барааны бичлэгийн тоонд харьцуулахад 2,5%, нийт мэдүүлгийн 6,5%-ийг эзэлж байна. Алдаатай мэдүүлгийн нь 1403 өөрөө гаальд мэдүүлэх, 70619 нь ГБМ-ээр дамжуулан мэдүүлсэн. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 2,0% байна.

					ГБМ-ийн мэдүүлгийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулсан мөн үеийн дүнгээс 0,1%-аар өссөн дүнтэй байна. 5. -Гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд 3 удаагийн чиглэл зөвлөмжийг хүргүүлсэн. -ГБМ-ийг /ceps.gaali.mn/-д зөвхөн нэг тоон гарын үсгээр нэвтрүүлдэг болгон програмд өөрчлөлт оруулж, нийт 53 давхардсан тоон гарын үсгийг цэгцэлж, анхааруулга өгч ажилласан. -ГБМ-ий анхан шатны сургалтыг МУИС-ын Бизнесийн сургуультай хамтран зохион байгуулах асуудлыг Захиргааны зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. МУИС болон ГЕГ-ын хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн "Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох сургалт"-ыг зохион байгуулахаар хоёр тал харилцан тохиролцож гэрээ байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Сургалтын төв, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран сургалтыг зохион байгуулж байна. -Сургалтын төвтэй хамтран 62, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран 43, нийт 105 хүнийг ГБМ-ийн анхан шатны сургалтад хамруулсан. Мөн 2025.06.05-наас 76 хүнтэй 2 анги МУИС-д хичээллэж байна. -ГБМ-ий давтан сургалтыг 3 удаагийн давтамжтай зохион байгуулж, сургалтад 186 ГБМ хамрагдаж, 176 ГБМ-ийн хугацааг сунгаж ажиллалаа. -Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/19 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.18 заалтыг үндэслэн, ГЕГ-ын тушаалаар 10 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг сэргээсэн. - Зөрчлийн тухай хуулийн 11.21.14 дэх заалтыг 2 удаа зөрчсөн 2 ГБМ-ийн эрхийг хүчингүй болгож, сүлжээнд ажиллах эрхийг хаасан. Давтан сургалтад хамрагдаж шалгалтад амжилтгүй дүн үзүүлсэн 3 ГБМ-ийн эрхийг хүчингүй болгосон. -Гаалийн газар, хороодын дарга нарт гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж, системд ажиллах эрх нээлгэсэн гаалийн		
--	--	--	--	--	--	--	--

					бүртгэгдсэн мэргэжилнүүдийг нэрсийг хүргүүлж, дадлага, туршлага хуримтлуулах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эхний 6 сарын хугацаанд томилогдсон газар тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн тухайн гаалийн газар хорооны хяналтад байгаа барааг мэдүүлэхэд анхаарч, хяналт тавьж ажиллахыг мэдэгдсэн. -2024 оны сүүлийн хагас жилд идэвхтэй ажилласан 351 ГБМ-ийг тусгай зөвшөөрлийн цахим системд дүгнэж, 5 ГБМ-д хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Зөрчлийн тухай хуулийн 11.21.14 дэх заалтыг 2 удаа зөрчсөн 2 ГБМ-ийн эрхийг хүчингүй болгож, сүлжээнд ажиллах эрхийг хаасан. Давтан шалгалтаар амжилтгүй дүн үзүүлсэн 3 ГБМ-ийн эрхийг хүчингүй болгосон -Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд зориулсан анхан шатны болон давтан сургалтанд БАҮХ-ээс ГУАБ Н.Цолмон, ГУБ Ц.Урантуул, Г.Баярмаа, Н.Отгонцэцэг нар барааны ангилал, үнэлгээ, гаалийн зуучлагч чиглэлээр хичээл зааж, нийт 361 суралцагч хамрагдсан. -Сургалтын төвийн 2026 оны сургалтын төлөвлөгөөнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан болон давтан сургалтад хамрагдах суралцагчдын тоог гарган тусгуулахаар хүргүүлсэн.		
2	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Ажлын цагийн хоцролт, тасалдалгүй ажилласан байна.	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу газрын бүх албан хаагч нар цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай үед гадуур ажиллах, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд CERP-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. ГЕГ-ын даргын Б/86 тушаалын дагуу ГУАБ Н.Цолмон 15 хоногийн чөлөө авсан. 4345 мин буюу 72.4 цаг илүү ажилласан байна.	01.01-06.10	95%
Зорилт 3: Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
1	Гаалийн үнэлгээ, барааны ангилалтай холбоотой маргаан,	Хэрэгжилт, хувиар	95%	Гаалийн үнэлгээний асуудлаар ирүүлсэн гомдол, маргааныг хугацаанд нь хянаж, шийдвэрлэн CAIS	1. Гаалийн үнэлгээний чиглэлээр ААН, иргэнээс ирүүлсэн 42 гомдол, маргааныг хянаж, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажилласнаар шийдвэрийн дагуу 839,1 сая төгрөгийн татварыг	01.01-06.10	95%

	гомдлын шийдвэрлэлт, хяналт тавьсан байдал,			програмын шийдвэрийн санд тухай бүр оруулж, баяжуулах.	улсын төсөвт нэмж төвлөрүүлээд байна. 1 гомдлын шийдвэрийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй байна. Шийдвэрийг CAIS програмын шийдвэрийн санд бүртгэсэн. 2. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт Нурхайч ХХК-ийг шалгуулахаар 2025.04.22-ны өдрийн 02-2.1/156 дотоод зурвасаар хандсан. 3. Бүрдүүлэлтийн цахим төвд 7 удаа дотоод зурвасаар чиглэл, зөвлөмж хүргүүлэн ажилласан. 4. Гадаад хамтын ажиллагааны хэлтсээр дамжуулан Австралийн болон БНХАУ-ын Хөх хотын гаалийн байгууллагаас үнийн мэдээлэл авахаар 2 удаа дотоод зурвас хүргүүлсэн. 5. Барааны ангилалтай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 5 хүсэлт, 5 гомдлыг судлан, нийт хариу албан бичиг боловсруулан хугацаанд нь хүргүүлж, гомдлын шийдвэрийн санд тухай бүр оруулж ажиллав.		
2	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	60%	Зарим барааны гаалийн үнийг системээс хянаж, баталгаажуулахтай холбоотой холбогдох эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулан, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулсан байна.	1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэн, СЯ-ны Татварын бодлогын газарт танилцуулан, хуулийн төсөл дээр яамны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Хуулийн төслийг СЯ-ны хууль, журмын төсөлд санал авах хуудсанд байршуулсан. 2. Монгол Улсын "Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйл болон татварын чөлөөлөлттэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Монголын гаалийн зуучлалын нэгдсэн холбоонд 02-2/102 тоот албан бичгээр чиглэл, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. 3. Монгол-Солонгосын ЭЗТХ-ийн багт орж ажиллан, ЭЗХЯ-наас ирүүлсэн албан бичгийн хүрээнд дараагийн хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд зарим мэдээ, тайлан гаргаж хүргүүлсэн. Монгол Улсаас экспортлох бараа, бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес	01.01-06.10	95%

					эрхлэгч нартай ЭЗХЯам, МҮХАҮТ, ГЕГ-ын хамтарсан уулзалт 2025.03.10-ны өдөр хийж, ЭЗТХ-ийн явц, тохирч байгаа тарифын жагсаалт, барааны асуудлаар мэдээлэл хийсэн. БНСУ-тай байгуулах ЭЗТХ, Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудтай байгуулах худалдааны түр хэлэлцээртэй холбоотойгоор ЭЗХЯ-наас ирүүлсэн албан бичгийн дагуу гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтын 2, 4, 5, 6, 7, 8 оронгийн кодын бичиглэлийг монгол, англи, орос хэлээр бэлтгэн хариуг файлаар хүргүүлсэн. БНСУ-ын ЭЗТХэлэлцээрийн сүүлийн раунд хийгдэхээр хүлээгдэж байна. 4. "МУ, Япон Улсын ЭЗТХ-ИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭД ХОРООНЫ III УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ АСУУДЛААРХ ЦАХИМ УУЛЗАЛТ 2025.04.25-ны өдөр болж, хуралдаанд Япон Улсын ЭЗХЯ, Монголын талаас ЭЗХЯ, ГХЯ, Монгол дахь Япон Улсын ЭСЯ, ГЕГ-ыг төлөөлж БАҮХ-ийн дарга, ГУАБ нар оролцож мэдээлэл хийв. 5. ЗУГ-аас ГТГТХ-ийн хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой зүйл, заалтыг ирүүлэх дотоод зурвасын дагуу хэлтчийн чиг үүргийн зүйл заалтыг гаргаж, 2025.05.07-ны 02-2.1/170 дотоод зурвасаар өгсөн байна.		
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сангийн сайдаас өгсөн үүрэг даалгаврын хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой заалтын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Гаалийн бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлснээр гаалийн зуучлагчид тавих хяналтыг сайжруулах зорилгоор ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай журам"-ыг шинэчлэн боловсруулж, гаалийн байгууллагын цахим хаягт санал авахаар байршуулан, журмын төслийг МЗХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. ГЕГ-ын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг батлуулж, холбогдох нөлөөллийн дүн шинжилгээ хийж ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2. МУИС болон ГЕГ-ын хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн "Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох сургалт"-ыг МУИС-тай хамтарн зохион байгуулах асуудлыг 33-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Хамтын ажиллагааны гэрээг Хуулийн хэлтэс, сургалтын	01.01-06.10	95%

				хөтөлбөрийг Сургалтын төвөөр хянуулж батлуулан харилцан тохиролцож гэрээ байгуулсны дүнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтыг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалт, 2025 оны 04 дугаар сарын 14-ны өдрийн "Шалгалтын комисс томилох тухай" А/140 дүгээр тушаалаар томилогдсон шалгалтын комисс 2025 оны 05 дугаар сарын 05-наас 05 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдсан суралцагчдаас 2025 оны 05 дүгээр сарын 26-ны өдөр Сорил шалгалт, 05 дугаар сарын 27-ны өдөр Ярилцлага шалгалтыг зохион байгуулж авлаа. Шалгалтад 43 суралцагч тэнцэж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр МУИС, ГЕГ-аас гэрчилгээг гардуулан өглөө. Дараагийн сургалтыг 6 сарын 4-ний өдрөөс 73 хүнтэй 2 ангиар зохион байгуулан ажиллаж байна. 3. ГТГТХ-ийн 38.1.20, 38.1.21, 40.4 болон 40.5-т заасны дагуу, ЗГ-ын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгуулах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв аймгийн Баян сумд баригдах цахилгаан станцын зориулалттай 1700 барааны кодыг тодорхойлж, ЭХЯ, СЯ-нд хүргүүлсэн. 4. Автомашины гаалийн үнийг системээс шалгаж, баталгаажуулах програмыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Гаалийн ерөнхий газрын 2025.01.22-ны өдрийн "Журамд нэмэлт оруулах тухай" А/17, А/18 дугаар тушаалуудыг батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтэст 2025.01.23-ны өдрийн 02/366 тоот албан бичгээр хүргүүлсэн. Яамнаас 2025.02.06-ны өдрийн 1/709 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтэд дурдсаны дагуу тушаалын тэмдэглэл хэсгийн хуулийн шаардлагыг залруулан 2025.02.19-ний өдрийн 01/782 тоот албан бичгээр хүргүүлсэн. Дээрх 2 тушаалд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн авч, санд холбогдох өөрчлөлтийг хийсэн	
--	--	--	--	---	--

					талаар 2025.03.21-ний өдрийн 1/1475 тоот албан бичгээр хариу ирсэн болно.		
4	Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцох ажлыг эрчимжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	Нэгжийн эрсдлийг тодорхойлж, бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.	1. ХАСХОМ-ээ шинэчлэн хуулийн хугацаанд хянуулан, цахимаар илгээсэн. 2. ААН, иргэдэд гаалийн үнэлгээний чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгч, гарсан шийдвэрийн үндэслэл тайлбарыг тодорхой мэдэгдэж ажилласан. 3. Гаалийн үнийн хяналтыг сайжруулах, дүн шинжилгээ хийх ажлыг хөнгөвчилөх зорилгоор Tablue программд дашбоард-р гаргах дараах 3 бодлогын даалгавар боловсруулж МТГ-т хүргүүлж, холбоотой ажилласан. Үүнд: - Дахин нэхэмжлэх үүсгэж байгаа байдал өдөр тутмын хяналт тавих, дүн шинжилгээ хийх /хийгдсэн/ - Автомашины бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх /Хийгдэж байна/ - Үнийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх /Автомашины дашбоардын дараа хийгдэж эхэлнэ/ 4. Үнийн мэдээллийн санг цахимаар бүрдүүлэх чиглэлээр 2 бодлогын даалгаврыг МТГ-т хүргүүлж, холбогдон ажиллаж, програм хийгдсэн. Програмыг нэвтрүүлснээр хязгаарлагдмал боловсон хүчнийг зөв хуваарилах, хүний оролцоотой механик ажиллагаа багасч, алдаа гарах эрсдэл буурч байна. 5. БАҮХ-ийн БТКУС хариуцсан ГУБ 2024 онд тэтгэвэрт гарсантай холбогдуулан орон тооны асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ГЕГ-ын дарга, удирдлагуудад албан хүсэлтийг удаа дараа тавьж, дотоод зурвасыг хүргүүлж ажилласны дүнд ГЕГ-ын даргын 2025 оны дугаар тушаалаар СТ-ийн БТКУС хариуцсан ГУБ Г.Баярмааг тус хэлтэст томилон ажиллуулж байна. Мөн ЧХОУНБГГ 2 ГУБ-г тус хэлтэст түр томилон ажиллуулсан. 6. Гаалийн байгууллагын системийн хэмжээнд барааны ангиллын асуудлаар эрсдлийг бууруулах, албан хаагчдын чадавхийг сайжруулах зорилгоор ГЕГ-ын БАҮХ-ээс ДГБ-д хүсэлт тавьсны дагуу Дэлхийн Гаалийн Байгууллагаас "Уялдуулсан систем болон Барааны Ангиллын Урьдчилсан Шийдвэр" сэдэвт үндэсний хэмжээний сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. ДГБ-ын экспертүүдээс	01.01-06.10	95%

					Монголын гаалийн байгууллагад барааны ангиллын урьдчилсан шийдвэрийн тогтолцоог бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудлын хүрээнд ДГБ-аас онош зүйн дүн шинжилгээ хийх хөтөлбөр /WCO Diagnostic mission/ хэрэгжүүлэх бүрэн боломтой талаар мэдэгдсэн нь чухал ач холбогдолтой болсон. 7. АТГ, ГЕГ-аас хамтран гаалийн зуучлагч байгууллага, ГБМ-нд тавих хяналтыг сайжруулах зорилгоор хамтарсан уулзалтыг 2025.05.27-ны өдөр з/б-сан. Уулзалтын хөтөлбөрийн дагуу "Гаалийн зуучлагч байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд үүсч болзошгүй авлига, ашиг сонирхлын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах төлөвлөгөө"-г БАҮХ-ээс АТГ, ЗУГ-тай хамтран боловсруулж танилцуулан, ГЗуучлагчдын мэргэшсэн холбооноос санал авч ГЕГ-ын дэд дарга 2025.05.30-ны өдөр баталсан. Төлөвлөгөөг АТГ, ГЕГ, ГЗ байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.		
5	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажилласан байна.	ЗДАП-аар ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн 3, ТОГ-аас 4, Захиргааны зөвлөлийн хуралдаанаас өгсөн 1 үүрэг даалгавар, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар өгсөн 1, нийт 9 үүрэг даалгавар болон ХШҮДАГ-аас өгсөн 10 зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тухай бүр програмд хугацаанд нь оруулсан. Үүнд: 1. Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу "Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох сургалт"-ыг МУИС-тай хамтран зохион байгуулахаар хоёр тал харилцан тохиролцож гэрээ байгуулан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 05-наас 05 дугаар сарын 23-ны хооронд амжилттай зохион байгуулж ажиллалаа. ГЕГ-ын даргын 2025 оны 04 дугаар сарын 14-ны өдрийн "Шалгалтын комисс томилох тухай" А/140 дүгээр тушаалаар томилогдсон шалгалтын комисс анхан шатны сургалтад хамрагдсан суралцагчдаас 2025 оны 05 дүгээр сарын 26-ны өдөр Сорил шалгалт, 05 дугаар сарын 27-ны өдөр Ярилцлага шалгалтыг зохион байгуулж авлаа. Шалгалтад 43 суралцагч тэнцэж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр МУИС, ГЕГ-аас гэрчилгээг гардуулан өглөө. Дараагийн	01.01-06.10	95%

				сургалтыг 2025 оны 6 сарын 4-ний өдөр эхлүүлэн, нийт 73 хүнийг хамруулан зохион байгуулж эхэлсэн. 2. МЗХ-аас гарсан шийдвэрийн дагуу Дэлхийн гаалийн байгууллагад барааны ангиллын чиглэлээр асуудал хэлэлцүүлэхтэй холбогдуулан албан захиа хүргүүлж, ДГБ-ын 9 сард хуралдах 76 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа хүргүүлсэн. Мөн ДГБ-аас ирүүлсэн ангиллын зөвлөмжийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал асуулгыг ДГБ-д бэлтгэн хүргүүллээ. ДГБ-аас хариу албан захиа ирүүлсний дагуу бэлтгэл ажлын хүрээнд бараатай холбоотой зарим нарийвчилсан үзүүлэлтүүд, техникийн шаардлага зохицуулалтуудын талаар холбогдох тайлбарыг бэлтгэн хүргүүлэхээр ажиллаж байна. Гаалийн газар, хороодод ДГБ-ын барааны ангиллын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай ГЕГ-ын дэд даргын 2025 оны 04 сарын 03-ны өдрийн 02/1361 тоот албан бичгийг хүргүүлсэн. 3. ТОГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БЦТ-өөс ирүүлсэн БНСУ-аас импортлогдсон ачааны автомашин, шатахуун тээвэрлэгч автоцистерн, БНХАУ-аас импортлогдсон өөрөө буулгагч, чирэгч, чиргүүлийн үнийн судалгааг хянаж, 4 удаа чиглэл хүргүүлэн, CAIS системийн тээврийн хэрэгслийн үнийн судалгаа хэсэгт оруулан, 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үнийн хяналтын зорилгоор ашиглаж, үнийн нэгдмэл байдлыг хангах боломж бүрдүүлсэн. Үүнд: 1. ГЕГ-ын даргын 2025.04.07-ны өдөр баталсан "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний дагуу 2025 оны 04, 05 дугаар саруудад хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2. Хил орчмын үнийн судалгааг хамтран зохион байгуулж /ЗҮГГ, БӨГГ СЭГГ/ үнийн мэдээллийн санд оруулах үүрэг даалгаврын хэрэгжилт, /100% дүгнэсэн/ 3. Барилгын материал, уул уурхайн техник, тоног төхөөрөмж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, хүнд машин, механизм, чирэгч толгой, чиргүүл зэрэг барааны гаалийн үнийн судалгааг хийж, үнийн мэдээллийн санг баяжуулах. Үнийн нэгдмэл		
--	--	--	--	---	--	--

				тухай УИХ-ын тогтоолын төсөлд холбогдох саналыг өгч ажиллав. 6. БАҮХ-ийн 2024 онд хийгдсэн онцлог ажлууд, 2025 оны зорилтын талаар танилцуулга материалыг ppt-р гарган ТОГ-ын удирдлагад танилцуулан хүргүүлсэн. 7. ДХБ-д гаалийн үнэлгээний асуудлаар Мэдэгдэл 3-ыг англи хэл дээр боловсруулан ГХЯ-нд 2025.06.20-ны өдрийн 01-1/2533 тоот албан бичгээр хүргүүлсэн. 8. БЦТ-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэгт ажиллаж, мэдүүлэгт татварын нэхэмжлэх дахин үүсгэсэн байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнгийн дагуу БЦТ дээр цаашид авах арга хэмжээний саналд тусгасан. 9. МУИС- ГЕГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан, давтан сургалтанд хамрагдсан ГБМ нараас 3 удаагийн ярилцлага шалгалт авах ажлыг зохион байгуулсан ажиллав.		
--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	ДГБ-ын Уялдуулсан Системийн Хорооны хуралдаанд онлайнаар оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	ДГБ-ын УСХ-ны 75 дугаар хуралдаанд онлайнаар оролцох.	1. ДГБ-ын Уялдуулсан системийн Хорооны 75 дугаар хуралдаанд 3-р сарын 10-21-ны өдрүүдэд цахимаар оролцов. Тус хуралдаанаар БТКУС-ийн Жагсаалтад оруулах нэмэлт, өөрчлөлтийн 2028 оны хувилбарыг хэлэлцэж батлахаар шийдвэрлэсэн.	01.01-06.10	95
2	Монгол-Солонгосын ЭЗТХ-ийн ажлын хэсгийн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	ЭЗТХ-ийн АХ-ийн хуралдаанд оролцох, Хэлэлцээний багт орж ажиллах	1. Монгол-Солонгосын ЭЗТХ-ийн багт орж ажиллан, ЭЗХЯ-наас ирүүлсэн албан бичгийн хүрээнд дараагийн хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд зарим мэдээ, тайлан гаргах ажлыг хийж зохион байгуулан ГЕГ-ын албан тоотоор хүргүүлсэн. Монгол Улсаас экспортлох бараа, бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес эрхлэгч нартай	01.01-06.10	95

					байдлыг хангах ажлыг хамтран хийх үүрэг даалгаврын хэрэгжилт, /100% дүгнэсэн/ 4. Үнийн мэдээллийн санг баяжуулж, үнэлгээний 2, 3-р аргын хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж, тайланг ТОГ-т ирүүлэх үүрэг даалгаврын хэрэгжилт, /81% дүгнэсэн/ 5. ХШУДАГ-аас өгсөн ҮМС-г шалгуурт заасан үзүүлэлтэд хүргэх чиглэлд ажил зохион байгуулах зөвлөмжийн хэрэгжилт. /100% дүгнэсэн/		
6	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, хувиар	100%	Цаг үеийн шинжтэй арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах	1. Замын-Үүд дэх гаалийн газраас ирүүлсэн тус гаалийн газраар бүрдүүлэлт хийгдсэн импортын гаалийн мэдүүлгийн гаалийн үнэлгээг бууруулсан байдалд хийсэн товч судалгаатай холбогдуулан 2024 онд ЗҮГГ-т хийгдсэн импортын гаалийн мэдүүлэгт давхар нэхэмжлэх үүсгэсэн байдалд дүн шинжилгээ хийж, танилцуулга мэдээллийг удирдлагад өгсөн. 2. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, СЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу татварын багц хуулийг шинэчлэх ажлын хүрээнд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үндэслэлийн хамт бэлтгэж Хуулийн хэлтэст 02-2/103 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. 3. СЯ-нд тээврийн зардалтай холбоотой 2022-2024 оны гаалийн бүрдүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, холбогдох тооцоо судалгааг гарган, танилцуулгын хамт хүргүүлсэн. 4. СЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу татварын багц хуулийг шинэчлэх ажлын хүрээнд ГЕГ-аас батлагдсан төлөвлөгөөний дагуу "Гаалийн зуучлагч байгууллага", "Гаалийн баталгаат агуулах эрхлэгчид, ГХБ эзэмшигч" нарт зориулсан 2 удаагийн хэлэлцүүлэгт оролцож, ГТГТХ, НӨАТ хууль болон ГТ хуулийн хэрэгжилт, санал, хүсэлтийг сонссон. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөнд тэдний саналыг тусгах ажлыг хийж, төслийг Хуулийн хэлтэст хүргүүлсэн. 5. Тамхины хяналтын тухай хууль, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалттай холбоотой Ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төсөл, гаалийн тарифт нэмэлт, өөрчлөлт оруулах		95%

	бүрэлдэхүүнд орж ажиллах				ЭЗХЯам, МҮХАҮТ, ГЕГ-ын хамтарсан уулзалт 2025.03.10-ны өдөр хийж, ЭЗТХ-ийн явц, тохирч байгаа тарифын жагсаалт, барааны асуудлаар мэдээлэл хийсэн. Гаалийн байгууллагатай холбоотой асуудлаар БАҮХ-ийн ГУАБ Н.Цолмон холбогдох асуултанд хариулт өгч оролцов. 2. "МУ, Япон Улсын ЭЗТХ-ийн хамтын ажиллагааны дэд хорооны III уулзалтын бэлтгэлийг хангах асуудлаарх цахим уулзалт 2025.04.25-ны өдөр болж, хуралдаанд Япон Улсын талаас ЭЗХЯ, холбогдох яамдын төлөөлөл, Монголын талаас ЭЗХЯ, ГХЯ, Монгол дахь Япон Улсын ЭСЯ, ГЕГ-ыг төлөөлж БАҮХ-ийн дарга, ГУАБ нар оролцож мэдээлэл хийв. 2 улсын талаас гарал үүслийн гэрчилгээг автоматжуулсан талаар танилцуулж, ГҮ гэрчилгээг онлайнаар харилцан хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэв.		
3	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Шинээр батлагдсан УИХ, ЗГ-ын тогтоол, ГЕГ-ын даргын тушаал, шийдвэртэй тухай бүр танилцан ажиллах	1. ДГБ, БНСУ-ын Гаалийн байгууллага, ГЕГ-аас 2025.05.19-05.23-ны өдрүүдэд зохион байгуулсан "Уялдуулсан систем болон барааны ангиллын урьдчилсан шийдвэр" сэдэвт үндэсний сургалтад хамрагдаж, холбогдох танилцуулга ппт-г орчуулах ажлыг хийж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. 2. БӨГГ-ын 4 ГУБ нарыг удирдаж Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 1 сараас 6 сарын 5-ны өдрийг хүртэл гаалийн үнэлгээ, барааны ангилал, Бараа нийлүүлэх нөхцөл, гарал үүслийн дүрэм, чөлөөт худалдааны хэлэлцээр, гадаад худалдааны бичиг баримт, анхаарах асуудлууд зэрэг сэдвээр он лайн хичээл зааж тус гаалийн газрын ГУБ нарыг удирдаж гаалийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэв. 3. МУИС- ГЕГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтанд ДХБ ба гаалийн үнэ, үнэлгээ, бараан нийлүүлэх нөхцөл сэдвээр 10 цагийн хичээл зааж, ГБМ-дэд гаалийн хэргийн хууль эрх зүйн мэдлэг олгох, тэдний чадавхийг дээшлүүлэхэд оролцож ажиллав.	01.01-06.10	95

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


Н.ЦОЛМОН /

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ НЭРГҮЙН ЦОЛМОНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Барааны ангилал, үнэлгээний хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1: Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх					
1	Гадаад худалдаа эрхлэгчид барааны ангиллын кодын талаар мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх	57	10	67	
2	- Зарим барааны гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлыг өргөжүүлэх - Гаалийн үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цахимжуулах	57	10	67	
3	Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрлийн системд гаалийн зуучлалын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах асуудлыг шийдвэрлэх	57	10	67	
Зорилт 3: Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх					
1.	Барааны ангилал, гаалийн үнэлгээтэй холбоотой аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн гомдол маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэх	57	10	67	
2.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	57	10	67	
3.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актыг хэрэгжүүлэх	57	10	67	
4.	Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцох ажлыг эрчимжүүлэх	57	10	67	
5.	Үүрэг даалгаврын биелэлт	57	10	67	
6.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	57	10	67	
Дундаж оноо:				67	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж,
-----	----------------------------------	----------------	---------------------------	--

		биелэлтийг хувь		дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	ДГБ-ын Уялдуулсан Системийн Хорооны хуралдаанд онлайнаар оролцох	95	14.25	
2.	Монгол-Солонгосын ЭЗТХ-ийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах	95	14.25	
3.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	95	14.25	
Дундаж оноо:				

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
Дундаж оноо:		7	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	67
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.25
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8

5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(96.25 оноо)
Нийт оноо = 96.25 (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Ч.Чимгэрэл/


2025. 06.10

(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Н.Цолмон/


2025. 06.10

(огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Г.Энхтайван/

2025. 06.25

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн ГУАБ
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Ө.Тэгшээ/


2025. 06.25

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Дарга
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Р.Отгонжаргал/

2025. 06.25

(огноо)